Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,911,767.5 мянган төгрөгөөр буюу 44,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	5,062.0	8,823.4	3,761.4
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	63,541.2	48,637.3	(14,903.9)
Үндсэн хөрөнгө	17,763,104.2	25,686,014.1	7,922,910.0
Нийт хөрөнгө	17,831,707.4	25,743,474.8	7,911,767.5
Өр төлбөр	-	10,066.3	10,066.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	17,831,707.4	25,733,408.6	7,901,701.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	17,831,707.4	25,743,474.8	7,911,767.5

Дээрх хүснэгтээс харахад: Авлага дансны үлдэгдэл хувь хүмүүсээс авах авлага 4,080.0 мянган төгрөгөөр буурч, байгууллагаас авах авлага 7,841.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Тантра энерги ХХК руу гүйлгээ давхардаж хийснээс авлага үүссэн.

Бараа материал дансны хувьд тусгай зориулалтын материал 182.3 мянган төгрөг, аж ахуйн материал 11,436.3 мянган төгрөг, бичиг хэргийн материал 1,451.3 мянган төгрөг, бусад хангамжийн материал 1,834.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж, орон сууц 192,559.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 3,391.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 46,922.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан үндсэн хөрөнгө 79,857.0 мянган төгрөг, шилжүүлсэн үндсэн хөрөнгө 59,195.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 192,559.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 51,636.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 68,810.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 9,129,296.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 9,020.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 24,643.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 25,733,409.0 мянган төгрөг болж 7,901,701.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Засаг даргын тамгын газар нь 2023 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,142,545.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 1,233,170.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2023 оны урсгал зардлын төсвийг 2,375,715.9 мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд батлагдсан төсөвт өөрчлөлт орж 3,338,911.5 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь 2023 онд алба хаагчдын цалин шат дараатайгаар нэмэгдсэнээс шалтгаалан орон нутгийн төсвийн санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 3,338,914.80 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Урьд оны үлдэгдлээс санхүүжсэн дүн 750,000.0 мянган төгрөг, Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,942,272.7 мянган төгрөг буюу 88,1 хувьтай байгаа нь бусад зардлын төсвийг 396,639.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

						/мянган төгрөгөөр/
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	70106/80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	795,438.70	791,060.77	4,377.9	99.4%	
2	70106/ 80106 Баг хорооны ҮА зардал	501,143.40	499,577.8	1,565.6	99.7%	
3	70106/80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	46,575.00	45,808.6	766.4	98.3%	
4	70106/80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	30,387.7	29,560.2	824.5	97.3%	
5	70106/80918 Бусад	1,943,370.00	1,554,265.8	389,104.2	78%	
6	70106/ 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	15,000.00	15,000.00	0	100%	
7	70106/82801 Улсын их баяр наадам	5,000.0	4,999.5	0.5	99.9%	
8	71411/81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	2,000.00	2,000.00	0	100%	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн захиргааны албан хаагчийн орон нутгийн нэмэгдэл цалин 78,583.1 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс 4,050.3 мянган төгрөг, аймгийн хөрөнгө оруулалтаар 648,016.9 мянган төгрөг, өвс тэжээлийн үнэ 11,786.0 мянган төгрөг, Манзуширын постын үнэ 37,936.2 мянган төгрөг, Шагналын мөнгө 1,500.0 мянган төгрөг, Улаанбаатар смарт картаас 1,420.3 мянган төгрөг, Ротари клубээс 2,679.8 мянган төгрөг, түрээсийн орлого 2,400.0 мянган төгрөг нийт 788,342.6 мянган төгрөгийн орлого орсон байна.

Төрийн захиргааны албан хаагчийн орон нутгийн нэмэгдэл цалин 75,600.0 мянган төгрөг, мал тооллогын урамшуулалд 3,600.0 мянган төгрөг, багын шагналд 1,500.0 мянган төгрөг, Автобусны картын үнэд 1,420.0 мянган төгрөг, өвс тэжээлийн үнэд 8,300.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 627,300.0 мянган төгрөгийг шилжүүлж 82,516.1 мянган төгрөг татан төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106/ орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах	88.1%	3,336,914.80	2,940,272.67
2	71411/Хүрээлэн буй орчны бодлого удирдлага	2023.01.01-2023.12.31	хэвийн үйл ажиллагааг хангах	100%	2,000.0	2,000.00

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Зуунмод сумын Засаг даргын захирамжаар 2,718,754.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Зуунмод сумын тохижилт, засварын 20 төсөл арга хэмжээг 1,295,195.1 мянган төгрөгөөр худалдан авахаар төлөвлөсөн бөгөөд харьцуулалтын аргаар 661,7731.7 мянган төгрөг, нээлттэй тендер шалгаруулалтаар 386,789.5 мянган төгрөгийн ажлыг Тусгал Төв ХХК, Би Си Би ХХК, Төв гэрэл ХХК, Тунбааш ХХК, Эрчим Өгий ХХК, Тантра Энержи ХХК, Хэрмэн шар үзүүр ХХК, Өгөөмөр Уул ХХК тус тус шалгаран гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэсэн байна.

Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд түлш халаалт, цэвэр бохир усны зардлыг Төв Чандмань ДЭХГ, гэрэл цахилгааны зардлыг УБЦТС ХК-тай шууд гэрээ байгуулан нийт 208,872.3 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авсан байна. Шатахууны зардлыг МТ Баянзүрх, Ник Дундад бүс, Төвт хайрхан ХХК, Тэнгэрлэг хад ХХК-аас 58,558.7 мянган төгрөгийн худалдан авалтыг тус тус хийсэн байна.

Арина компьютерс ХХК, Бест компьютер технологи ХХК, БСБ компьютер ХХК, Гэрэгэ системс ХХК, Мотопомп ХХК, Нано хархорум ХХК, Номин ХХК, Нэгүн хаус ХХК, Өнөтэгш арвижих ХХК, Өсөх наран өөдөө ХХК, Хашконтакт ХХК, Эн си эс ХХК-аас 24 нэр төрлийн 30 ширхэг компьютер тоног төхөөрөмжийг 51,636.1 мянган төгрөгөөр шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Бат боловсрлын үр ХХК, Дэмт ХХК, Лока ХХК, Лут өрнөх ХХК, Өсөх наран өөдөө ХХК, Уянгын гурван эрдэнэ ХХК, Үржих тэнгис ХХК, Хашконтакт ХХК-аас 22 нэр төрлийн 90 ширхэг тавилга эд хогшлыг 69,960.0 мянган төгрөгөөр шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Ерөнхий гэрээгээр цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Адъяасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06/63 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын тамгын газрын батлагдсан 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 762,162.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 11,432.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9,145.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын тамгын газар нь байгууллагад бүртгэлтэй 0003ТӨА, 0009ТӨА, 7048ТӨА улсын дугаарыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасны дагуу цэнхэр дэвсгэрээр сольсон байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын тамгын газарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 169 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроож, 162 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,003,324.6 мянган төгрөгийн гүйлгээ, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 446,537.9 мянган төгрөгийн гүйлгээ, Төсөв хөрөнгө зарцуулах тухай 18 ширхэг шийдвэрийг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байсан ба аудитын явцад нөхөн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж, 4 албан шаардлага, 1 төлбөрийн акт өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 06/401 албан тоотой ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	79.2	1	79.2	100%
Албан шаардлага	4	186,406.0	4	186,406.0	100%
Зөвлөмж	1	666,001.6	1	666,001.6	100%
Нийт дүн	6	852,486.8	6	852,486.8	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нийт 3,459,732.5 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 3,459,732.5 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

1. Хөрөнгийн шинжтэй 850.0 мянган төгрөгийн үнэтэй теннисний ширээ, 9,020.0 мянган төгрөгийн үнэтэй Каунти автобусны моторыг бараа материалын дансанд орлогодож авсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт”, “ангилал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,003,324.6 мянган төгрөгийн гүйлгээ, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 446,537.9 мянган төгрөгийн гүйлгээ, Төсөв хөрөнгө зарцуулах тухай 18 ширхэг шийдвэрийг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байна. Энэ шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Цалин хөлсийг зөрүүтэй олгосон.

Илрүүлэлт: Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн Б/02 тоот захирамж, Зуунмод сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн Б/02 захирамжийг үндэслэн улс төрийн 8 албан хаагчид орон нутгийн нэмэгдэл 14,703.7 мянган төгрөг олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа

болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

2. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.

Илрүүлэлт: Зуунмод сумын ЗДТГ нь 6 багын Засаг даргадаа хантааз 360.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

3. Төсвийн зарлагыг буруу тооцоолсон.

Илрүүлэлт: Тантра энерги ХХК руу 7,841.4 мянган төгрөгийг илүү шилжүүлэн авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэг хүлээнэ" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

1. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.

Илрүүлэлт: Зөвлөгөөн арга хэмжээнд зарцуулахаар төсвийн хөрөнгөөр зэс аяга 40 ширхэг 1,621.0 мянган төгрөг, мөнгөн аяга 3 ширхэг 490.0 мянган төгрөг, үзэг 28 ширхэг 1,064.0 мянган төгрөг, ноолууран ороолт 23 ширхэг 2,787.0 мянган төгрөг, нийт 5,108.0 мянган төгрөгөөр гарын бэлэг бэлдсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглоно” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан

тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан 4.2.1.11-д “Хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Зуунмод сумын ЗДТГ-ын авто тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй 6801ТӨҮ, 9436УНЧ, 4936УБВ, 2778ТӨВ, 5060ТӨВ улсын дугааруудад тод дэвсгэр бүхий улсын дугаар аваагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх зөвлөмж өгөв.

2. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Зуунмод сумын ЗДТГ-ын биет бус хөрөнгийн бүртгэлд 10 газар, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн газрын бүртгэлд 37 газар бүртгэлтэй байгаа бөгөөд бүртгэгдсэн газрын тоо болон үнэлгээний дүн тус тус зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Газрыг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн /цаашид "иргэн" гэх/, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуульд заасны дагуу эзэмшиж ашиглана”, 23 дугаар зүйлийн 23.3.9 “Аймаг нийслэлийн газрын алба нь газар эзэмших, ашиглах эрхийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28.1-д заасан журмын дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх эрхтэй”, 23 дугаар зүйлийн 23.4.3 “Сумын газрын даамал, дүүргийн газрын алба нь эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын хэмжээ заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, координатжуулах, тэдгээрийн кадастрын зургийг үйлдэж, газрын улсын бүртгэлд бүртгэх эрхтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай тооцоо нийлэх, зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлагналтай холбоотой алдаа	1	9,870.0			1	9,870.0	1	9,870.0				
Шилэн данс	1	3,449,862.5	1	3,449,862.5			1	3,449,862.5				
Дүн	2	3,459,732.5	1	3,449,862.5	1	9,870.0	2	3,459,732.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Улс төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл цалин олгосон.	1	14,703.7	1	14,703.7	-	-	-	-	-	-	-
Төсвийн хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авсан.	1	360.0	1	360.0								
Авлага үүсгэсэн.	1	7,841.4	1	7,841.4								
Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан:	1	5,108.0			1	5,108.0						
Тод өнгө бүхий улсын дугаар аваагүй	1	-					1	-				
Газрын бүртгэл зөрүүтэй	1	-					1	-				
Дүн	6	28,013.1	3	22,905.1	1	5,108.0	2	-	-	-	-	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn